Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Гурав дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х.Гүйцэтгэх захиргааны сонин.

7 дэх жилдээ №77 (1382) | 1964 оны 10 дугаар сарын 5 | ДАВАА

## Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажил

Монгол—Зөвлөлтийн ард түмний ган бат найрамдлын баталгаа болсон манай хоёр ард түмний баяр Монгол—Зөвлөлтийн найрамдлын уламжлалт сарын ажлыг манай эх орон даяар баяр баясгалантай нээж байна.

Энэ сарын ажил нь Октябрийн социалист их хувьсгалын 47 жилийн ойг угтан зохиогдож байгаа юмаа.

ЗХУ—ын өгөөмөр тусламжийн үр дүнг манай улсын 43 жилийн хөгжлийн түүх батлан харуулж байна. Дэлхийн хөдөлмөрчдийн их багш В.И.Ленин, монголын ард түмний гарамгай удирдагч Д.Сүхбаатар нар Монгол—Зөвлөлтийн ард түмний бат найрамдлыг үндэслэн тавьсан юм.

Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдал нь ардын хувьсгалын ялалтыг бэхжүүлэх, харийн дайснаас эх орноо хамгаалах, тус улсыг хөрөнгөтний биш хөгжлийн замаар хөгжүүлэх агуу их хэрэгт улам бүр зузааран батажсан юм.

ЗХУ—ын тусламжийн үр шим манай улсын хөгжил цэцэглэлтийн баталгаа болж байгаа бөгөөд манай орны хөдөлмөрчдөөс эх орондоо социализмыг байгуулах түшиг тулгуур нь болж байна. Жилдээ 50 мянган киловат цагийн эрчим гаргах цахилгаан станц, 500 мянгаас 1,1 сая тонн нүүрс гаргах ил уурхай, жилд 378 мянган шоо метр хивс үйлдвэрлэх үйлдвэр зэрэг орчин үеийн үйлдвэр ахуйн барилга байгуулалт бүхий социалист Дархан хотыг ЗХУ—ын тусламжаар байгуулж байгааг монгол хүн бүр найрамдлын бэлэг тэмдэг гэж бахархан баярладаг юм.

Манай оронд Зөвлөлт Холбоот Улсын өгөөмөр тусламж хүрээгүй үйлдвэр ахуйн газар нэг ч үгүй билээ. Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажил нь коммунизм байгуулж байгаа Зөвлөлтийн ард түмний баялаг туршлагаас сурч эзэмшихэд ихээхэн ач холбогдолтой юм.

Найрамдлын сарын ажлыг МАХН—ын Төв Хорооны заалт ёсоор Октябрийн социалист хувьсгалын 47 жилийн ойг хөдөлмөрийн их бүтээлээр угтах манай хоёр ард түмний ах дүүгийн мөнхийн найрамдал хамтын ажиллагааг улам бэхжүүлэх коммунизм өрнүүн байгуулж байгаа Зөвлөлтийн ард түмний гайхамшигт ололт амжилт болон олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний нэгдэл нягтралыг бэхжүүлэх талаар ЗХУКН—ын чармайлт, түүний энх тайванч ленинч гадаад бодлогыг хөдөлмөрчин олны дунд өргөн сурталчлах чиглэлийн дор явагдах юм.

Энэ заалтыг биелүүлэх явдал МЗНН-ийн байгууллагуудын гол зорилт мөн. Октябрийн социалист их хувьсгалын 47 жилийн ой ба Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажлыг хөдөлмөрийн өндөр амжилтаар тэмдэглэхийн тулд 1964 оны сүү тушаалт, үр тариа, хүнсний ногооны хураалт, мал өвөлжүүлэлтийн бэлтгэл зэрэг ажлыг биелүүлэхийн тулд социалист уралдааныг хөдөө аж ахуй, үйлдвэр, соёл гэгээрлийн байгууллагуудад өрнүүлж ажиллах хэрэгтэй.

МЗНН—ийн байгууллагуудаас найрамдлын сарын үеэр коммунизм байгуулж байгаа ЗХУ-ын баатарлаг ард түмний баялаг туршлагыг сурталчлан судлах, ЗХУ—ын Коммунист хөдөлмөрийн бригад, Лениний эв хамт залуучуудын эвлэлийн ажил, манайд ажиллаж байгаа Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн баялаг туршлага ажил амьдралаас сурах ажлыг зохих байгууллага үзэл суртлын ажлын бүхий л арга хэлбэрийг ашиглан зохиох нь чухал байна. Ялангуяа үйлдвэр аж ахуй, соёл гэгээрлийн бүх салаа салбарт Зөвлөлтийн хүмүүсийн соёлч дадал заншил, ажлын арга хэлбэрүүдийг нэвтрүүлэхэд МЗНН-ийн байгууллагуудын ажлыг чиглүүлэн ажиллах явдал чухлаар шаардагдаж байна.

### Баярын цахилгаан

ӨНЖҮҮЛ СУМЫН НАМЫН ҮҮР ДАМДИНСҮРЭН, АДХ—ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА АЮУШ НАРТ

Үр тарианы ургацын төлөвлөгөөг хугацаанд нь 127 хувиар биелүүлж улсад тариа тушаах үүргээ 200 хувиар биелүүлэх үүрэг авсанд баяр хүргэж сүү тушаалт, тарваганы арьс, ахрын ноос бэлтгэх, мал өвөлжилт зэрэг ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт аймгийн намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа бат итгэж байна.

**Аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Б.Дэжид**

**АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дарга Ц.Жамсран**

### Баярын цахилгаан

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРООНЫ НЭГДҮГЭЭР НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ДЭЖИД, АДХ—ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Ц.ЖАМСРАН НАР ТАНАА

Танай аймгийн нам-улсын байгууллагын биетэй туслалцаа хөдөлмөрчдийн идэвх чармайлтын дунд экспортын адуу тушаалт 107,2 хувиар биелсэнийг баяртай тэмдэглэж цаашдын ажилд амжилт хүсье.

Худалдаа бэлтгэлийн яамны сайд Ц.Доржготов

## Даалгавар биелүүлсэн дарга

Хавар цаг. Сангийн аж ахуйн даргын өрөөнөө Отгон гуай үүрэг авч суув. Сангийн аж ахуйн дарга Аръяа

—За Отгон гуай өнгөрсөн намар танай бригад улсад тушаах төмсний төлөвлөгөөг 9 хувиар тасалсаны дээр бусад төрөл бүрийн ногооны төлөвлөгөөг дөнгөж л биелүүлсэн шүүдээ.

Ирэх намар энэ дутагдлыг давтаж хэрхэвч болохгүй. Танай бригад өнгөрсөн хавар 75 га-д төмс тариалсан бол энэ хавар 100 га-д тариалах болно гэхэд нь Отгон гуай:

—Даргаа манайх 75 га-д төмс тарих үр авч үлдсэн шүүдээ гэв.

—Тэгвэл 100 га-гаас авах ургацын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд нэг га-гаас 13 тонноос доошгүй ургац авах зорилготой ажиллах хэрэгтэй байна гэснээр яриа төгсөж «МАХН-ын гишүүний хувьд энэ үүргийг биелүүлэх л хэрэгтэй дээ» гэж бодсоор Отгон гуай даргын өрөөнөөс гарсан билээ. Сангийн аж ахуйн даргын үүргийг биелүүлэхийн тулд ногоочдынхоо зөвлөлгөөнийг хийлгэж өнгөрсөн хавар хүн бүрт өөрсдийнх нь хүсэлтээр ногооны талбай бүрийг хариуцуулан агротехникийн шаардлагын дагуу арчилгаа тордлого хийлгэн өөрөө биечлэн зааварлах ажил хийж уйгагүй хөдөлмөрлөсний үрээр ургац нь ч сайн ургаж ногоогоо хурааж эхэлсэн ажээ.

Намар цаг. Отгон гуайн ажил дүгнэгдэж даалгаврын биелэлт шалгагдаж байна.

Тус бригадынхан 77 га-гаас төмс, 11,5 га-гаас байцаа, 7,5 га-гаас шар лууван, өргөст хэмх, орос сонгино хураажээ.

Га-гаас 13,4 тонн төмс, 35 тонн байцаа хураан улсад тушаах төмсний төлөвлөгөөг 200 хувиар биелүүлээд байгаагийн дээр 270 тонн байцаа, бусад ногоо 113 тонныг тус тус улсад тушаагаад байна. Эдний бригад 400 тонн байцаа тушаах төлөвлөгөөтэй бөгөөд уг төлөвлөгөөг



ЗУРАГ ДЭЭР: *Ногооны 8 дугаар бригадын дарга М.Отгон*

давуулж 600-гаад тонныг тушаах гэж байна. Тус бригадад 4—5 га-гийн төмс хариуцан га-гаас 16—17 тонн ургац авсан ногоочин Нямсүрэн, Долгор, Аяахүү, 3 га-гийн байцаа хариуцаж га-гаас 40 тонныг авсан Лагцаг, Доржжүгдэр, 3 га-гийн шар лууван хариуцаж га-гаас 20 тонн ургац авсан Баяндорж, Лхавгажав нарын сайчуул төрөн гарчээ.

Тэрчлэн сүүлийн хэдэн жилийн дотор Жаргалантын сангийн аж ахуйн хэмжээгээр өргөст хэмхийн төлөвлөгөө биелэгдэж байгаагүй учиртай билээ. Энэ бригадад нэг га-гийн өргөст хэмх хариуцан 17 тонн ургац авч улсын нормыг хол давуулсан залуу ногоочин О.Октябрь шинээр төрөн гарч амжилтын эзэн болжээ. Иймэрхүү дүнгээр Жаргалантын сангийн аж ахуйн ногооны 8 дугаар бригадын дарга М.Отгон хавар авсан даалгавараа биелүүлж ажлын бахдам амжилтаар дүнгээ гаргуулж байна.

**В.Дорж**

### НАМАР

**МАНАЙ АЙМАГ ХАДЛАНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ 88,2 ХУВИАР БИЕЛҮҮЛЭЭД БАЙНА.**

II нүүрт ИХ АЖИЛ ИД ДУНДАА | III нүүрт ХОЛБООЧДЫН ТУРШЛАГА | IV нүүрт МӨНХ НЭР

Жаргалантын сангийн аж ахуйнхан 9 дүгээр сарын 29-ний байдлаар 29641 га-гийн тариа ангилан хадаж төлөвлөгөөгөө 100 хувь биелүүлэн 21000 га-гийн тариа цайруулан улсад 9200 тонн үр тариа тушаагаад байна.

**Хонгор** намрын хосгүй их ажил ид дундаа өрнөж, Жаргалант, Загдал, Зөөхий, Тээл, Агьтийн өргөн хөндийнүүдээр ган хөлгийн янцгаалт газар дэлхийг доргилуулан галтай залуусын бахтай бүтээл тариалангийн талбайгаас ундарч байна.

Ууган сангийн аж ахуй маань буурь зааж энэ намрын тариа хураалтаар улсад 19800 тонн үр тариа тушаах атлаа 3520 тонныг илүү тушаах амлалт авч өөрийн эх орны бүх САА, МААМС, хөдөө аж ахуйн нэгдлүүдийн хамт олонд хандаж уриалга гаргаад амлалтаа амжилттай биелүүлэх гэж зориг бадрангуй ажиллаж байна.

САА-н захиргаа, нам, олон нийтийн байгууллагууд хамтран тариа хураалтын өмнө техникч нэг бүрээр амлалт авахуулсаны дээр тариа хураалтын үеэр зохион ухуулга олон түмний ажлыг сайн зохиож хүн бүрийн ажлыг тогтмол дүгнэн уралдаанд түрүүлэгчдийг урамшуулах ажлыг зохиож байгаа зэргээс техникчдийн идэвх санаачлага ихээхэн дээшилж ажлын явцыг түргэтгэх сайн нөлөө болж байна.

Тус САА—н Загдалын тасгийн Дамдинсүрэн даргатай тарианы 15 дугаар бригадынхан комбайнч Пүрэвсүрэн, Хишигдорж, Цоодол,

# Их ажил ид дундаа

Дэмбэрэл, Ганбаатар нарын зэрэг олон техникчид уралдаанд 1-3 удаа түрүүлжээ. Энэ бригадын дарга Дамдинсүрэнярихдаа:

—Манай бригад ажлын 12 хоногт 2900 гаруй га-гийн тариа ангилан хадаж төлөвлөгөөгөө биелүүлээд байгаагийн дээр 1900 га-гийн тариа цайруулж төлөвлөгөөнийхөө 70-аад хувийг биелүүлээд байна. Манай бригадын ажил иймэрхүү сайн яваа нь техник засварыг чанар сайтай хийсний дээр комбайнчид маань хоорондоо тусархаг, тэд нэг хүн шиг нэгэн санаатай ажилладгаас амжилт олж байна гэв.

Энэ бригад САА-нуудын удирдах газрын болзлыг 3 удаа хангаж САА-н тариа бригадуудын дотроос түрүүлж яваа учир бригадын дарга Дамдинсүрэн, тоо бүртгэгч Пунцаг болон 1963 оны аймгийн аварга тариаланч Пүрэвсүрэн нар сангийн аж ахуйн зардлаар улсын амралтанд амрах эрх олж аваад байна.

Тус САА-н тариа хураалтанд ажиллаж байгаа хурандаа Бухаа даргатай Ардын цэргийн авто тээврийн батeлоны байлдагчид, Монгол Улсын Их сургуулийн оюутнууд тун сайн ажиллаж байна. Ардын цэргийн авто тээвэрчид талбайгаас үтрэмд, үтрэмээс улсад тээвэрлэх будааг хаягдал гээгдэлгүй тээвэрлэхийн тулд замын донсолгоог тун сайтар гаргахын хамт машины тэвшийг байнга шалгаж байдгаас замд будаа хаях явдал гарахгүй байна.

Тээвэрчдийн дотроос байлдагч Халзанбаньд, Дашдаваа, Сүрэн, Жамсран нарын олон арван тээвэрчид тав хоногийн уралдааны дүнгээр байр эзлэн уралдаанд түрүүлжээ.

Мөн тус батeлоны 15 хүнтэй засварын бригадынхан энэ хугацаанд 120-иод авто машинд их дунд үйлчилгээ хийгээд байгаагийн дотроос засварчин Ренчиндорж, Цэрэн, Шагдарсүрэн нар сайн ажиллаж байна.

Иймхүү Жаргалантын САА-н тариа хураалтын их ажил ид дундаа амжилттай явагдаж байна.

Тус САА-н улсад тушаах будаа үтрэмэн дээр нилээд их байгаа боловч Баруун хараагийн будаа хүлээн авах салбар хүн хүчний хүрэлцээгүй, ажлын зохион байгуулалт муугаас, машиныг удаан хугацаагаар хүлээлгэж байгаа нь Жаргалантын САА-н ажилд муу нөлөө үзүүлж ажлын явцыг удаашруулж байна.

Жишээ нь: Загдалын тасгийн үтрэмээс өглөө 11 цагт будаа ачаад явсан машин шөнийн 2 цаг хагаст будаагаа буулгаад буцаж байгаагаас тодорхой байна.

Энэ талаар Баруун хараагийн будаа хүлээн авах салбарын хариуцлагатнууд сүрхий анхаарч будааг хүлээгдэлгүй түргэн буулгаж байхыг ид дундаа явагдаж байгаа их ажлын явц шаардаж байна.

## Нэгэн сургуулийн хоёр аварга



Угтаалын сургуулийн сурагч Л.Банзрагч 24,5 тонн өвс бухалдаж аварга хадланч болжээ.



Сурагч Т.Аюуш 100 хонь хяргаж 135 кг ноос авсаны дээр хотны ноос 5 кг-ыг түүж цагаан алтны аварга болжээ.

*Баатарын бариан дээр*

# *Сойлго таарсан хүрэн*

Сурвалжилсан тэмдэглэл



**АЛТАНХҮҮ БААТАР БОЛОХ НЭЭ!**

Ёроол нь харагдахгүй тэнгисийн гүн ус шиг, зах нь үл харагдах тариалангийн өргөн талбайд трактор комбайны эгнэн цувах нь тэнгисийн дээгүүр хөвөх загасчны завь лугаа адил харагдана.

Номгоны арын өргөн хөндийд зогсоо зайгүй хүрдэн сэлүүрээ наранд гялалзуулан өндөр ургасан өтгөн тариаг ханаруулан байгаа аварга комбайны жолоо залсан залуусыг харахад ажлын амт, атарчдын алдар сэтгэл зүрхнээ зурагдан үлдэнэ.

Уг нь би Алтанхүүтэй уулзахаар тэнд зорин очсон билээ.

Баруунаасаа зүүн тийш тоос манаруулан дарцаг дэрвүүлсээр яваа нэгэн комбайнчинтай уулзаж Алтанхүүг хаана явааг нь сургалахаар амдан зогсож байтал ашгүй тэр маань Алтанхүү байлаа.

Сайн хүн санаагаараа гэгчээр Алтанхүү нээрээ сайн залуудаа гэж хамт яваа нөхөр минь хэлээд уулзая гэсэн дохио болгон гараа өргөхөд Алтанхүү ч хариуд нь мэндийн хариу болгон гараа өргөөд жолоогоо мушгин талбай руугаа эргэлээ.

Аргагүй! Ажлын талбайд ид ажлын үеэр түүнд хүнтэй уулзах зав хаанаас байхав.

Бас тэгээд эх орныхоо өнцөг булан бүрт байгаа тариачин залуусыг уриалж амлалт авсан болохоор ажилдаа шамдах нь зүйн хэрэг шүү дээ.

Ер нь ч тэгээд Алтанхүү ажлын талбайд ганц ч минут сул зогсдоггүй ажээ.

Тэхдээ Алтанхүү цөөхөн минут зарцуулан бидэнд ажлынхаа амжилтаас дурьдан ярьсанюм. Алтанхүү анх МХЗЭ—ийн илгээлтээр Зэлтэрийн атрын сангийн аж ахуйд очиж улмаар Шаамарын сургууль комбинат төгсөж Угтаалын сангийн аж ахуйд ирж сангийн аж ахуйн үйлдвэрлэлтэй ажил амьдралаа холбожээ.

Алтанхүү тариа хураах техникээ сайн эзэмшиж тариан түрүү хаягдалгүй авч га-гаас авах ургацыг нэмэгдүүлэхийн төлөө шургуу ажиллаж байна.

Энэ залуу тариа хураалтанд орсон хэдэн хоногт 430 га-гийн тариа хадаж 6000 центнер будаа цайруулаад байв. Алтанхүү энэ намар түмэн центнер тариа хураах амлалт аваад одоо амласан амлалтынхаа 60 хувийг гүйцэтгээд байна.

Алтанхүү амжилтаа биелүүлэхийн тул техникээ байнга арчилан тордож өдөр бүрийнхээ тариа хураалтанд өглөөний 8 цагт гарч, үдийнхээ амралтыг талбай дээр өнгөрүүлж, шөнийн хоёр цагт ажлаасаа бууж амардаг аж.

Өдөрт тэрээр 18 га-гийн тариа хадах нормоо 30—40 га хадаж өдрийнхөө төлөвлөгөөг 166—222 хувиар биелүүлж байгаа нь амлалтаа биелүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Алтанхүү, БНМАУ—ын хөдөлмөрийн баатрын болзлыг өнгөрөгч хоёр жилийн дотор 2 удаа хангаад энэ жил гурав дахь удаагаа хангах гэж байгаа нь тариачин залуугийн энгэр дээрх Алтангадас одон, МХЗЭ—ийн Төв Хорооны тэргүүний тариаланч залуу алтан медалий нь дэргэд баатрын одон гялалзах нээ.

Тиймээ, МХЗЭ—ийн гишүүн Алтанхүү БНМАУ—ын хөдөлмөрийн баатар болж манай орны олон арван баатруудын нэрсийн жагсаалтанд нэгэн шинэ баатрын нэр бичигдэнэ.

Алтанхүү тариалангийн талбайд нэг ч минут сул зогсохгүй техник нь ямарч саатaлгүй байгаа нь тариа хураалтын өмнө техникээ сайн бэлтгэснийх буйзаа.

Ёстой л хүрэн улаан комбайных нь сойлго нь таарч хүсэлдээ хөтлөгдсөн залуугийн од нь гялалзаж явна.

## БОГ МАЛ ХЭЭЛТҮҮЛЭГ

Баянцогтын сангийн аж ахуй энэ жил 9700-гаад хонинд зохиомол хээлтүүлэг хийх төлөвлөгөөтэй ажээ. Тус сангийн аж ахуйн Жирэм хэмээх газар байгаа зохиомол хээлтүүлгийн хоёр салбар 9 дүгээр сарын 11-нээс эхлэн ажиллаж 20-ны байдлаар нийтдээ 13 суурийн 2786 хонинд хээлтүүлэг хийгээд байна.

Энд «Орхон» үүлдрийн 49 хуц ашиглагдаж байгаа бөгөөд хуцнуудад ногоон тэжээл, овъёос, тахианы өндөг, хужир шүү зэрэг нэмэгдэл тэжээл өгч байгаагаас үр сайн өгч байна гэж энэ хоёр салбарын зохиомол хээлтүүлгийн техникч Очиржанцан, Цэрэндэжид нар ярьж байна.

## НАМАР

**ҮР ТАРИА ХУРААХ ТӨЛӨГӨӨНИЙ 57,7 ХУВЬ НЬ БИЕЛЭГДЭВ.**

**Энэ нүүрийг манай сурвалжлагч Б. Дорж бэлтгэв.**

